



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 17 өдөр

Дугаар A/188

Мандалговь

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн  
оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн  
дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “д” дахь заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, оролцоог хангахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилго бүхий Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дэд хорооны дарга: Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт,  
хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга  
Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга  
Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын  
дарга  
Эрүүл мэндийн газрын дарга  
Мэргэжлийн хяналтын газрын дарга  
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга  
Боловсрол, соёл урлагийн газрын дарга  
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга  
Нийгмийн даатгалын хэлтсийн дарга  
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Ахмад  
настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал  
хариуцсан мэргэжилтэн  
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн  
Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн  
холбооны тэргүүн

Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн  
бодлогын хэлтсийн хөдөлмөр, нийгмийн хамгааллын  
бодлого хариуцсан мэргэжилтэн

2. Төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд хорооны даргад үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/385 дугаартай захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МОНХБАТ

4812100000